



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/181

Ховд

Урамшуулалт цалин олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3 дахь заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, хамт олноо манлайлан ажилласан албан хаагчдийн ажлын үр дүнг үнэлэн 3465000 төгрөг (гурван сая дөрвөн зуун жаран таван мянга)-ийн урамшуулалт цалин олгосугай.

2. Урамшуулалт цалин олгох албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Хавсралтад нэр дурдагдсан албан хаагчдад олгох 3465000 төгрөг (гурван сая дөрвөн зуун жаран таван мянга)-ийг цалингийн зардлаас гаргахыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

87
837

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн А/181 дүгээр тушаалын хавсралт



УРАМШУУЛАЛТ ЦАЛИН ОЛГОХ
АЛБАН ХААЧДЫН НЭРС

Д/д	Албан хаагчдын овог, нэр	Албан тушаал	Мөнгөн дүн
1.	Б.Энхмандал	Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд нягтлан бодогч	315 000
2.	Б.Нямдэлгэр	Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч	315 000
3.	Х.Болормаа	Санхүү, аж ахуйн тасгийн нярав	315 000
4.	Г.Оюунцэцэг	Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасгийн үйлчлэгч	315 000
5.	Ц.Батзориг	Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасгийн цахилгаанчин	315 000
6.	Х.Ганболд	Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн	315 000
7.	Л.Батгэрэл	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлийн хэлтсийн мэргэжилтэн	315 000
8.	Д.Жаргалсүрэн	Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасгийн үйлчлэгч	315 000
9.	Б.Жаргалсүрэн	Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасгийн үйлчлэгч	315 000
10.	Ө.Энхтайван	Санхүү, аж ахуйн тасгийн жолооч	315 000
11.	Б.Энхбаатар	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн	315 000
Дүн			3 465 000

-оОо-